

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

ИРГЭНИЙ ЗАРДАЛ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Иргэнд төрийн үйлчилгээ авах төлбөр, хураамж гарахгүй.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хувьд нэмэлт орон тоо, шинэ ажлын байрны шаардахгүй, нэмэлт зардал гарахгүй.

УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй.

-----oOo-----